



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ТӨМӨРБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 09 өдөр

Дугаар А/84

Төмөрбулаг сум

Г Шүлхий өвчнөөс урьдчилан
сэргийлэх дархлаажуулалтын арга
хэмжээг зохион байгуулах тухай


Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын А/281, Аймгийн засаг даргын А/394 дугаар захирамж, Аймгийн мал эмнэлгийн газрын даргын А/35 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг сумын хэмжээнд бүх үхэр сүргийг хамруулан 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 25 хоногийн хугацаанд төлөвлөгөөний дагуу шуурхай зохион байгуулсугай.

2. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг хэрэглэх заавар, стандарт ажиллагааны зааварчилгааг чанд баримтлан дархлаажуулалтыг технологит хугацаанд хийж гүйцэтгэхийг Ганболор ББН, Далайгүн ББН-ийн захирлуудад даалгасугай.

3. Шүлхийн дархлаажуулалтын гүйцэтгэлд хяналт тавих, тайлагнах, мэргэжил арга зүйгээр хангах, вакцины шилийг татан авч устгалын комисст хүлээлгэн өгч ажиллахыг Мал эмнэлгийн тасагт хариуцуулсугай.

4. Захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Г.Нямханд/-д үүрэг болгосугай.

ДАРГА  А.МӨНХ-ЭРДЭНЭ